



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 78

Номгон

Г
Үл хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдаа
зохион байгуулж, доод үнэ тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит 14 дүгээр хуралдааны 14/6 дугаар тогтоол, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам"-ын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын 1 айлын орон сууц, Эрүүл мэндийн төв, Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 1-3 тоот 12 айлын орон сууц, Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын орон сууц, Баянговь сумын Засаг даргын Тамгын газрын орон сууц, Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын конторын барилга, Шаргалжуут 8-р багийн Эрүүл мэндийн төвийн хөрөнгөд тус тус бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны доод үнийг хавсралтаар тогтоож дуудлагын худалдаагаар худалдсугай.

2. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Идэрмөнх-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Үл хөдлөх хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль журмын дагуу 2019 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 11⁰⁰ цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын 103 тоот өрөөнд зохион байгуулж, орлогыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын 100030051006 тоот дансанд төвлөрүүлэх;

2.2 Худалдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын хэрэгжилтийг 2019 оны 08 дугаар сард багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд ирүүлэх.

1190091

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Л.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ОТГОНБАЯР



Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 06 дугаар сарын 13-ны
өдрийн 72 дугаар тогтоолын хавсралт

ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Сумын нэр	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Тоо ширхэг	Анхны өртөг	Газрын хэмжээ	Дуудлагын худалдааны доод үнэ	Тайлбар
1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Шинэжинст сум	ЭМТ	Граж	2008.01.01	1	1 983 870,0		1 126 800,0	1976 онд баригдсан 2008 онд ашиглалтад орсон 36м2 талбайтай, хувь хүний эзэмшлийн газар дээр баригдсан. Бүрэн завсар хийх шаардлагатай
2	Шинэжинст сум	ЗДТГ	1 айлын сууц	1985.01.01	1	110 134 480,0	182	4 190 500,0	1985 онд ашиглалтад орсон 42м2 талбай бүхий 1 айлын сууц, модон цонхтой, дотор хаалгагүй, шал нь мөөгөнцөр үүссэн, инженерийн шугам сүлжээнд холбогдоогүй, сүүлийн 3 жил ашиглаагүй.
3	Эрдэнэцогт сум	ЗДТГ	Цагдаагийн байр/ 12 айлын орон сууц 1-3 тоот	14.12.25	1	13 000 000,0		11 738 500,0	1987 онд баригдсан 46,5м2 талбай бүхий 2 өрөөтэй орон сууц, Инженерийн шугам сүлжээнд холбогдоогүй, чулуун суурьтай блокон ханатай, модон цонхтой засвар хийх шаардлагатай. Газар олгогдоогүй нийтийн эзэмшлийнх
4	Шаргалжуут	ЭМТ	Эмнэлгийн барилга	89.01.01	1	75 700 730,0	240	21 450 150,0	1989 онд ашиглалтад орсон чулуун суурьтай, хана цууралт үүссэн, халаалт, тог байхгүй, модон цонхтой, цонхны рам цуурсан, эрүүл мэндийн үйл ажиллагаа явуулах зориулалтын бус 4 айлын орон сууцны зориулалттай 1 давхар барилга. Нам даралтын зуухаар халж байсан, 230,5м2 талбайтай зарим өрөөнд мөөгөнцөр үүссэн. Газрын хэмжээг барилгын суурийн хэмжээгээр тооцон гаргасан.

1	2	3	4	5	6	7	8	9	10
5	Бууцагаан сум	ЗДТГ	Орон сууц	91.01.01	1	8 988 000,0		4 156 207,0	1991 онд баригдсан 3 давхар, 27,8м2 талбай бүхий 2 өрөөтэй орон сууц, Инженерийн шугам сүлжээнд холбогдоогүй, бетонон суурьтай блокон ханатай, модон цонхтой засвар хийх шаардлагатай. Газар олгогдоогүй нийтийн эзэмшлийнх
6	Баянговь сум	ЗДТГ	Орон сууц	89.01.01	1	14 925 000,0	300	6 269 077,0	1989 онд баригдсан, бетонон суурьтай, блокон ханатай, инженерийн шугам сүлжээнд холбогдоогүй, цахилгааныг салгасан, ханын шавар нурсан, модон цонхтой, 50м2 талбай бүхий 2 өрөө орон сууц. Дахин үнэлгээгээр газрыг 600,0 мянган төгрөгөөр үнэлж орлого авсан тул данснаас хасах
7	Баян-Өндөр	ЗДТГ	Конторын барилга	76.10.15	1	185 550 000,0	787	18531572,00	1976 онд ашиглалтанд орсон чулуун суурьтай инженерийн шугам сүлжээнд холбогдоогүй, нам даралтын гар хийцний зуухаар халдаг байсан, цахилгааныг салгасан, хана цууралттай, тоосгон ханатай, модон хучилттай шувуун нуруу төмөр дээвэртэй, цэвэр ус ариутгах татуургад холбогдоогүй, 479.8 м2талбай бүхий 1 давхар барилга. Барилгын хаявч 55 хувь хагарсан. Гадна шавардлага 75 хувь нь суларч хөндийрсөн, дээвэрээс ус гоождог, дулаан алдагдалтай, даацын бус хананд ан цав үүссэн.
			Дүн					67462815,00	

000